

## 2014 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН ДААТГАЛЫН МЭДЭЭ

2014 оны 02 дугаар сарын 28

### 1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2014 оны 1 дүгээр сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн бүртгэлд дараах өөрчлөлт орсон байна.

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	/тоогоор/			
		2013.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2014.01.31
1	Даатгалын компани	17			17
2	Даатгалын компанийн салбар	251			251
3	Даатгалын төлөөлөгч	3187	23 <sup>1</sup>	44 <sup>2</sup>	3166
4	Даатгалын зуучлагч	20	1 <sup>3</sup>		21
5	Даатгалын хохирол үнэлэгч	15			15
6	Актуарч	15			15
7	Жолоочийн даатгалын зөвшөөрөл	16			16
8	Даатгалын зуучлагч компанийн салбар	39	12 <sup>4</sup>		51
9	Даатгалын компанийн төлөөлөгчийн газар	6			6

<sup>1</sup> Хорооны даргын 2014 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 03 дугаар тушаалаар “Монгол даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК-ийн 23 иргэнд даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гарсан байна.

<sup>2</sup>Хорооны даргын 2014 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 04 дүгээр тушаалаар “Монгол даатгал” ХХК-ийн 44 иргэнд даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гарсан байна.

<sup>3</sup>Хорооны даргын 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 21 дүгээр тушаалаар “Капитал банк” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

<sup>4</sup>Хорооны даргын 2014 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 08 дугаар тушаалаар “Хаан банк” ХХК-нь Сүхбаатар, Дорнод, Булган аймгуудад, Хорооны даргын 2014 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 21 дүгээр тушаалаар Сэлэнгэ, Хэнтий, Дорноговь, Сүхбаатар, Дархан, Өвөрхангай, Дундговь, Хөвсгөл, Говьсүмбэр аймгуудад тус тус даатгалын зуучлагч компанийн салбар нээн ажиллуулахыг зөвшөөрсөн байна.

### 2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2014 оны 1 дүгээр сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг сарын болон өссөн дүнгээр харуулбал дараах байдалтай байна.

**Ердийн даатгалын компаниудын хувьд :**

	/төгрөгөөр/
Үзүүлэлт	2014.01.31
	/сарын дүн/

Даатгалын нийт хураамж	17 492 201 351,57
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж	882 510 140,11
Олгосон нийт нөхөн төлбөр	2 786 656 885,02
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр	1 306 434 147,45
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо	2 818,00
Давхар даатгалд төлсөн хураамж	1 046 047 500,19
Байгуулсан даатгалын гэрээний тоо	142 482,00
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний тоо	12 426,00
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо	18 941,00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	172 322 000 000,00
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөр	86 331 744,31

2014 оны 01 дүгээр сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын хураамжийн орлого 17492.2 сая төгрөг, үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж 882.5 сая төгрөг, олгосон нөхөн төлбөр 2786.7 сая төгрөг ба үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр 1306.4 сая төгрөг болсон байна. Эндээс даатгалын хохирлын харьцаа сарын байдлаар 16.0 хувь болсон бөгөөд өмнөх сараас 12.1 пунктээр буурсан байна.

Ердийн даатгалын компаниудын 2014 оны 01 дүгээр сард байгуулсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр даатгалын үнэлгээ бүхий гэрээ нь “Тэнгэр даатгал” ХХК-ийн даатгалын 172.3 тэрбум төгрөгийн үнэлгээтэй гэрээ юм. Хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөрийг “Монгол даатгал” ХХК 86.3 сая төгрөгийг олгосон байна.

### Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

	/төгрөгөөр/
2014/01/31	
Даатгалын нийт хураамж	27 684 923,00
Олгосон нийт нөхөн төлбөр	48 906 741,00
Давхар даатгалд төлсөн хураамж	350 000,00
Байгуулсан даатгалын гэрээний тоо	10,00
Хугацаат амьдралын даатгал	1,00
Насан туршийн даатгал	3,00
Хуримтлалын даатгал	5,00
Тэтгэврийн даатгалд	0,00
Эрүүл мэндийн даатгал	1,00
Аннуити даатгал	0,00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээтэй гэрээ	0,00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	1 500 000 000,00

Хамгийн их дүнтэй нөхөн төлбөр	0,00
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	10 555 000,00

Урт хугацааны даатгагч 2014 оны 01 дүгээр сарын байдлаар 27.7 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой, 48.9 сая төгрөгийг нөхөн төлбөрт олгосон байна. Даатгалын хохирлын харьцаа 176.6 хувьтай байна.

**Даатгалын зуучлагч компаниудын хувьд :**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2014.01.31 /сарын дүн/
Нийт орлого	17 918 241 475,74
Даатгалын зуучлагчийн орлого	149 133 195,74
Үүнээс: Сайн дурын даатгал	55 474 952,24
Албан журмын даатгал	78 756 600,50
Даатгуулагчаас зуучлагчаар дамжин төлсөн даатгалын хураамж	336 986 224,38
Зуучилсан даатгалын гэрээний тоо	8 695,00
Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээ	9 009 788 102,38

2014 оны 01 дүгээр сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын зуучлагч компаниуд 149.1 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлого олсон байна. Үүний 37.1 хувийг сайн дурын даатгалаас үлдсэн хувийг албан журмын даатгалын хураамжийн орлогоос бүрдүүлсэн байна. “Асимон брокерс” ХХК-ийн зуучилсан гэрээ даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр 8610.9 сая төгрөгийн үнэлгээтэй байна.

Даатгалын зуучлагч компаниудаас “Гэрэлт буян ундрах” ХХК, “Эм жи ай би” ХХК, “Эс би ай эс” ХХК, “Пийс оф лайф” ХХК-иуд тус тус орлогогүй ажилласан байна.

“Хас банк” ХХК, ХХК, “, “Ренессанс групп” ХХК, “Си эн энэ икс” ХХК-иуд тус тус 01 дүгээр сарын мэдээг ирүүлээгүй байна.

**Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2014.01.31 /сарын дүн/
Нийт орлого	61 820 130,91
Даатгалын хохирол үнэлгээний орлого	49 531 171,36
Үүнээс: Сайн дурын даатгал	9 887 541,64
Албан журмын даатгал	24 543 629,72
Үнэлсэн даатгалын хохирлын тоо	1 629,00
Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	133 208 326,00

2014 оны 01 дүгээр сарын байдлаар даатгалын хохирол үнэлэгч компаниуд 49.5 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Үүнээс 20.0 хувийг сайн дурын, үлдсэн хувийг албан журмын даатгалын хохиролын үнэлгээний орлогоос төвлөрүүлсэн байна.

“Фэйр валюшн” ХХК нь даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн болох 27.6 сая төгрөгийн үнэлгээг хийсэн байна.

“Тэгш сонголт эстимэйт” ХХК нь 01 дүгээр сарын мэдээг ирүүлээгүй байна.

## **БУСАД**

Хорооны даргын 2014 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр тушаалаар “Лояалти солюшн” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай шийдвэр, Хорооны 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 20 дугаар тогтоолоор “Нэйшнл лайф даатгал” ХХК-д хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай шийдвэрийг тус тус гаргасан байна.

## **ДААТГАЛЫН ГАЗАР**